

МОНГОЛ УЛС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САР  
ТУТМЫН ТОЙМ

2015.10

Үзүүлэлтүүд:

<p><b>ДНБ 2.5%</b> 2015 оны III-р улирал</p>	<p>ГШХО 9-р сард <b>-42.4 сая ам.доллар</b></p>	<p>Төсвийн тэнцэл <b>-915.3 тэр бум төгрөг</b></p>	<p>Инфляци <b>3.4%</b></p>	<p>Чанаргүй зээл <b>855 тэрбум төгрөг</b></p>	<p>Валютын нөөц <b>1.5 тэрбум ам.доллар</b></p>
<p>ХАА салбар 12.8%, аж үйлдвэр, үйлчилгээний салбар 6.2%-иар тус тус өссөн нь нөлөөлөв.</p>	<p>Цэвэр ГШХО 9-р сарын байдлаар өмнөх сараас (58.2) сая ам.доллар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад (89.7) сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.</p>	<p>Төсвийн орлого 4.56 их наяд төгрөг, зарлага 5.48 их наяд төгрөг, тэнцэл 915.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.</p>	<p>Өмнөх сараас 0.7 хувь буурч, оны эхнээс 1.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 4.9 хувь хувиар өслөө.</p>	<p>Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 2.2% буюу 19 тэрбум төгрөгөөр өсч, 855 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 7.2%</p>	<p>Монголбанкны валютын нөөц өмнөх сараас 10.3 хувь буюу 145 сая ам.доллараар өсч 1542.7 сая ам.долларт хүрэв.</p>



Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш

**1993.35**



Орон сууцны үнийн индекс

**1.071**

Өмнөх сараас 2%-иар, оны эхнээс 9.9%-иар тус тус буурлаа.



Монголбанкны бодлогын хүү


**13%**



Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар ХБНГУ-ын Холбооны Ерөнхийлөгч Иоахим Гаук 2015 оны аравдугаар сарын 14-16-ны өдрүүдэд Монгол Улсад төрийн айлчлал хийлээ.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, оны эцсийн байдлаар хүснэгтээр үзүүлээ.







Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд (Мянган ам.доллар, тонн)

Голдох бүтээгдэхүүн	2012 он		2013 он		2014 он	
	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар
Чулуун нүүрс	20574	1 880 396	18 194	1 116 153	1 106	850 615
Төмрийн хүдэр	6415	532 509	6725	654 333	8 338	448 378
Зэсийн баяжмал	575	838 780	650	948 951	1 378	2 575 636
<b>Нийт</b>	<b>27564</b>	<b>3 251 685</b>	<b>25 569</b>	<b>2 719 437</b>	<b>10 822</b>	<b>3 874 629</b>

Эх сурвалж: УЦХороо

Эдийн засгийн байдал хүнд байгаа үед төрийн албанд 10 хувийн цомхтгол хийх чиглэлийг Засгийн газар барьж буй энэ үед эхний ээлжид дэд сайд нарын албан тушаалыг цомхотгов.



**Мөнгө**

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2015 оны аравдугаар сарын эцэст 9.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 34 тэрбум төгрөг буюу 0.3%-иар, өмнөх оны мөн үеэс 72 тэрбум төгрөг буюу 0.7%-иар тус тус буурчээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө тайлант сард 739.7 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 28.1 тэрбум төгрөг буюу 3.8%, өнгөрсөн оны мөн үеэс 70 тэрбум төгрөг буюу 8.6%-иар буурчээ.

**Мөнгөний нийлүүлэлт**



**Хадгаламж**

Нийт хадгаламж 2015 оны 10-р сард 7.3 их наяд төгрөг хэвээр байгаа бөгөөд өмнөх сараас 1.52 тэрбум төгрөг буюу 0.8 хувиар өссөн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 253.3 тэрбум төгрөг буюу 4.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Ийнхүү өмнөх сараас нийт хадгаламж өсөхөд төгрөгийн хадгаламж 2.1 хувиар буюу 108 тэрбум төгрөг, валютын хадгаламж 2.2 хувиар буюу 47.4 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

**Хадгаламж**



**Зээл**

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2015 оны аравдугаар сарын байдлаар 11.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 25 тэрбум төгрөг буюу 0.2%-иар, өмнөх оны мөн үеэс 920 тэрбум төгрөг буюу 7.2%-иар тус тус буурлаа. Харин чанаргүй зээлийн хэмжээ 855 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 2.2% (19 тэрбум төгрөг)-иар, өнгөрсөн оны мөн үеэс 41.1% (249 тэрбум төгрөг)-иар тус тус өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 7.2%-ийг эзэлж байна.


**Нийт зээлийн хэмжээ**



**Ипотекийн зээл**

2015 оны 10-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 1.5 хувь (50.8 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 24.7 хувь (666.7 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 3.3 их наяд төгрөгт хүрэв. Есдүгээр сард нийт 1029 зээлдэгчид 50.8 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 75877-д хүрлээ. Ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.4 хувь нь төгрөгийн, 1.6 хувь нь гадаад валютын зээл байгаа ба нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээл 0.7 хувийг эзэлж байна.

**Ипотекийн зээлийн хэмжээ**




\* Эх сурвалж Монголбанк

## Гадаад худалдаа

### Гадаад худалдаа


2015 оны аравдугаар сард худалдааны нийт бараа эргэлт 7 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 3926.4 сая ам.доллар, импорт 3163.3 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 763.4 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 1990 сая ам.доллар буюу 21.9 хувь, үүний дотор импортын хэмжээ 679 сая ам.доллар буюу 14.7 хувиар, экспортын хэмжээ 1311 сая ам.доллар буюу 29.3 хувиар тус тус буурчээ. Буурсан гол шалтгаан нь ашигт малтмалын импорт, тээврийн хэрэгслийн импорт, машин, цахилгаан бараа, эрдэс бүтээгдэхүүнийн хэмжээ тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.



\* Эх сурвалж: УСХ, МБ

### Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2015 оны есдүгээр сард 42.4 сая ам.долларын сөрөг дүнтэй гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 89.7 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Гадаадын шууд хөрөнгө оруулалтад МУ-аас гадаадруу гаргасан хөрөнгө оруулалт 0.1 сая ам.доллар байсан бол Монгол Улсад 26.6 сая ам.долларын сөрөг үр дүнтэй хөрөнгө оруулалт хийгдэв. 2015 он гарсаар шууд хөрөнгө оруулалт 4,5,6-р саруудад тогтвортой байсан бол бусад саруудад сөрөг үр дүнтэй гарчээ.



\* Эх сурвалж: МонголБанк


**Монгол Улсын гадаад өр**

**Гадаад өр**

2015 оны гуравдугаар улиралд Засгийн газрын нийт гадаад өр 3.5 тэрбум ам.доллар, нийт гадаад өрийн үлдэгдэл 21.4 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 5.3 хувь (199.9 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 0.8 хувь (190 сая ам.доллар)-аар тус тус буурсан байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 16 хувийг засгийн газрын өр, 10 хувийг Төв банкны өр, 9 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 16 хувийг бусад салбаруудын өр, 49 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна. Төв банкны нийт өрийн 97 хувийг богино хугацаат, 3 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



**МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨРИЙН БҮТЭЦ ХУВИАР**



\* Эх сурвалж Монголбанк

**Сарын онцлох үйл явдал**

- 10.16** Аж үйлдвэрийн яамнаас санаачлан зохион байгуулж буй “Монголд үйлдвэрлэв” аж үйлдвэрийн чуулган Шангрилла зочид буудалд болов. Тус чуулганд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, мэргэжлийн холбоод, төрийн болон төрийн бус байгууллага, үйлдвэрлэгчид, эдийн засагчид, банк санхүүгийн байгууллагын төлөөлөл оролцов.
- 10.22** Японы Ерөнхий сайд Шинзо Абэ энэ сарын 22-нд Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын зорилго Тавантолгойн Зүүн чиглэлийн төмөр замын төсөлд хамтран ажиллах, иж бүрнээр бүтээн байгуулах ажилд Японы талыг оролцуулах асуудлаар харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан явдал байв.
- 10.22** Засгийн газрын бондын ээлжит арилжаагаар 1 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3 жилийн хугацаатай 10.0 тэрбум ЗГБ-ыг арилжихаар нийтэд мэдээлснээр 5.0 тэрбум төгрөгийн санал иржээ. Тэгвэл Монголбанк 5.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын бондыг 15.800 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр арилжааллаа.

**Тойм****2015 оны 3-р улирлын Оюутолгойн үйлдвэрлэл**

Монголбанкны бодлогын хүү 13 хувтай байгаа тул тэр хэмжээгээр хадгаламж, зээлийн хүү өсч, мөнгөний олодоц ховордох болов. Гадаадын хөрөнгө оруулалт татарч эдийн засгийн өсөлт 2015 оны гуравдугаар улирлын байдлаар 2.5 хувь болов. Оюутолгойн далд уурхайн үйлдвэрлэл эхэлснээр эдийн засаг сэргэх хүлээлттэй байгаа юм. Гуравдугаар улиралд Оюутолгой компани 56 мянган тн зэс бүхий баяжмал, 123 мянган унц алт бүхий баяжмал, 388 мянган унц мөнгө бүхий баяжмал үйлдвэрлэсэн байна. Харин зэсийн хэмжээ хүдэр дэх агууламж нэмэгдсэн учир 1.3 хувиар өсчээ. Алтны хэмжээ өмнөх улирлаас 48.5 хувиар буурсан үзүүлэлт гарсан байна. Далд уурхайг хөгжүүлэх гэрээг зурж, шинэчилсэн ТЭЗҮ-г Монголын Ашигт малтмалын газар наймдугаар сард хүлээн авч урьдчилсан бэлтгэл ажлыг хангаж капиталын зарцуулалтын тооцоог шинэчлэх ажлыг 2016 оны нэгдүгээр улиралд багтаан дуусгахаар ажиллаж байна. Оюутолгой компани 2015 оны эцэст далд уурхайн санхүүжилтыг шийдэж, 2016 оны хоёрдугаар улирлын эхээр бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр төлөвлөж байна.

**ХБНГУ-ын Холбооны Ерөнхийлөгч Иоахим Гаукын Монгол дахь айлчлал**

Монгол Улсын ерөнхийлөгчийн урилгаар 2 хоног айлчилсан ХБНГУ-ын Холбооны Ерөнхийлөгч Иоахим Гаук Монгол, Германы шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх тухай баримт бичгүүдэд хоёр тал гарын үсэг зурлаа. Мөн ашигт малтмал, аж үйлдвэрийн салбарт хамтран ажиллах Монгол, Германы хувийн хэвшлийнхэн хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.